

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02-р сарын 18-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.13.16 дахь хэсэг, 11 дүгээр бүлэг болон 2022 оны 02 сарын 18-ны өдөр хуралдсан “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2021 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 1,589,280,000 /Нэг тэрбум таван зуун наян есөн сая хоёр зуун наян мянга/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохыг зөвшөөрсүгэй.
2. “Сүү” ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 4,62 /Дөрвөн төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгож, ногдол ашгийг тараах, түүнтэй холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д олгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Сүү” ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн олгож, 2022 оны 12 сарын 31-ний өдрийн дотор тарааж дуусгасугай.
5. Энэхүү шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ГАНБААТАР

